

ТАНИЛЦУУЛГА

“Согтуурч, мансуурч донтох өвчтэй хүнийг албадан эмчлэх тухай” хуулийн төслийн тухай

Согтуурах, мансуурах донтой, өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль 2000 онд батлагдсанаас хойш дөрвөн удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Өнгөрсөн хугацаанд тус хуулийг мөрдөн ажиллах явцад зарим заалт нь хэрэгжих боломжгүй, зарим зохицуулалтыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай болсон нөхцөл байдал үүссэн учраас хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенцид “...шүүхийн шийдвэрээр ногдуулсан шийтгэлийн үр дүнд аливаа этгээдээр гүйцэтгүүлэх ажил буюу үйлчилгээ”-г конвенцийн “албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр” гэдэг нэр томъёонд оруулахгүй байхаар зааж, “Энэхүү конвенцийг соёрхон баталсан Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын гишүүн бүр албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн бүх хэлбэрийг аль болох богино хугацаанд арилгах үүрэг хүлээнэ” гэжээ.

Мөн Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенцид албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн аливаа хэлбэрийг хориглож, “...хүмүүжлийн арга хэрэгсэл болгох...” зэрэг зорилгоор ашиглахыг таслан зогсоохоор заасан.

Иймд согтуурах, мансуурах донтой өвчтэй хүнийг шүүхийн шийдвэрээр албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх нь шийтгэл ногдуулж байгаа биш учраас энэ хуулиас албадан хөдөлмөр хийлгэхтэй холбогдсон зохицуулалтыг хассан.

Одоогийн мөрдөж байгаа хуульд Албадан эмчлэх газар нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяалалд байх бөгөөд түүний албадан эмчлэх мэргэжлийн удирдлагыг эрүүл мэндийн байгууллага хэрэгжүүлнэ гэж заасан боловч мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх ажил хангалтгүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад эмчлэх мэргэжлийн удирдлага, боловсон хүчнээр хангах, мэргэшүүлэх, давтан сургах чиг үүрэг байдаггүй тул энэ чиглэлээр эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хэрэгжүүлэх ажлыг хуулийн төсөлд тусгалаа.

“Донтох өвчнөөр өвчлөгсдөд ногдуулах захиргааны арга хэмжээ, бусад орны туршлага” сэдвээр Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийсэн судалгааны дүнгээс үзэхэд албадан эмчилгээг ихэвчлэн тухайн улсуудын эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллаж байгаа жишиг түгээмэл байна.

Одоогийн байдлаар Албадан эмчлэх газар нь улсын хэмжээнд нэг л байгаа бөгөөд эмчлүүлж байгаа өвчтөний тоо байнга өсөн нэмэгдэж, тус газрын хүчин чадал хүрэлцэхгүй байгаагаас үзэхэд цаашид энэ чиглэлийн эмчилгээ, үйлчилгээ явуулдаг газрын тоог нэмэх эсхүл бусад эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаатай уялдуулж, бодлогын хэмжээнд шийдвэрлэх хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Албадан эмчлэх газраас гаргасан судалгаанаас үзэхэд согтуурах донтой өвчтэйн улмаас эмчлүүлэхээр ирж байгаа хүмүүсийн 50-60% нь ямар нэгэн суурь өвчтэй ирдэг бөгөөд үүнээс болж эмчилгээнд хамрагдах боломжгүй, эсхүл эмчилгээг дундаас нь зогсоох болдог байна. 2010-2013 оны байдлаар нийт 249 хүн харшлах өвчний улмаас архины эмчилгээнд бүрэн хамрагдаж чадаагүй байна.

Иймээс эмнэлгийн дүгнэлт гаргахад тухайн хүн албадан эмчилгээ хийлгэхэд харшлах өвчтэй эсэхийг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг шинжилгээ хийж тогтоосон байхыг шаардаж, харшлах өвчтэй тохиолдолд албадан эмчилгээнд явуулахыг хориглосон заалт орууллаа.

Хүнд сонголт хийх боломж олгох зорилгоор эмнэлгийн дүгнэлт гарсны дараа өөрөө сайн дураараа эмчилгээ хийлгэх хүсэлтээ гаргасан, гэр бүл нь дэмжсэн нөхцөлд албадахгүй байхаар зохицуулалт нэмсэн.

Албадан эмчилгээнд явуулах ажиллагааны явцад гарч буй зөрчил, дутагдлыг арилгах үүднээс хуулийн төсөлд шүүх хуралдаанд албадан эмчилгээ хийлгэх хүнийг өөрийг нь оролцуулах талаар тухайлан зааж өглөө. Мөн Албадан эмчлэх газарт эмчлүүлэхээр ирж байгаа хүнийг хүлээн авах ажиллагааг одоо мөрдөж байгаа хуульд зааснаас дэлгэрэнгүй тусгалаа.

Судалгаанаас үзэхэд бусад оронд донтох өвчинтэй тэмцэх нь өндөр өртөг бүхий эмнэлгийн үйлчилгээ болж байдаг бөгөөд хэдий зардал, өртөг өндөр ч үр дүн нь нийгэмд хэмжихээргүй эерэг бол тухайн үйл ажиллагаанд хөрөнгө төсөвлөх хэрэгтэй гэж үзэх байр сууринаас ханддаг байна.

Албадан эмчлэх газрын зардалд тооцож оруулдаггүйгээс шаардлагатай мөртлөө шийдвэрлэгддэггүй байсан тухайлбал, архины эмчилгээнд хамрагдаж байгаа хүнд илэрсэн бусад өвчнийг эмчлэх, эмнэлгийн хувцас, эмчилгээний хоолны болон өвчтөнийг буцаах зардлыг албадан эмчлэх газрын зардалд оруулж тооцохоор тусгав.

Төсөлд эмчлүүлэгчийн эрх үүргийг зааж, эмнэлгийн дэг журам зөрчиж, архидан согтуурч, мансуурсан тохиолдолд тусгаарлах өрөөнд эмчийн зөвшөөрлөөр, харуул хамгаалалтын ажилтны хяналтад эрүүлжүүлэхээр тусгалаа.

Албадан эмчлэх хугацаа нь эмчлүүлэгчийн биеийн байдал, эмчилгээний явцаас хамаарах учир хуулийн төсөлд зөвхөн доод хязгаарыг гурван сар гэж заалаа.

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт албадан эмчлүүлсний дараа авах арга хэмжээ болон нийгмийн халамжид хамруулах ажиллагааны талаар заалаа.Согтуурч, мансуурч донтох өвчинтэй тэмцэх, донтох өвчтэй болсон хүмүүсийг албадан эмчлэх асуудлыг зохицуулах нь төрийн орхиж болохгүй үүрэг, нийгмийн халамжийн бодлогын нэгээхэн хэсэг байх нь зайлшгүй байна.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ